

Хойт мэргэн тэвнийн домог

ХОЙТ
МЭРГЭН
ТЭВНИЙН
ДОМОГ



ХОЙТ МЭРГЭН ТЭВНИЙН ДОМОГ

Эрт урьдын цагт гэнэ

Элэнц хуланцийн үед гэнэ

Энэ газраас хол гэнэ

Эгц хойт зүгт гэнэ

Нэр усгүй нэгэн өвгөн амьдарч байж гэнэ. Хүн амьтнаас хэтэрсэн цэцэн мэргэн ухаантай, үдийн замд босгосон тэвнийн сүвэгчийг сэт харвадаг гайхалтай цэцэн харваач болохоор Хойт мэргэн Тэвнэ гэж алдаршсан гэнэ. Тэр олны дунд тэнэг төрсөн Аравсар гэгч ганц хүүтэй, орчлон дээрээс олдошгүй "Хар хилэн согсор" гэгч хурдан шартай юм байж гэнэ.

Хүү нь даанч тэнэг болохоор яаж хүн болгох, яаж бэр буулгах билээ гэж л санаа зовон суудаг байжээ. Нэгэн өдөр хүү Аравсараа дуудаж,

– Аавын буйд элгэн саднаа таньдаг, агтын буйд газар усыг үздэг. Одоо хүү минь,

Гадна дотно явах болжээ

Газар усыг үзэх болжээ

Гал голомт манах болжээ

Ганц ааваа тэжээх болжээ

Аав нь чамд зуун хуц өгье. Чи зүглэсэн зүгтээ зуун хоног явж худалдаа хийгээд ир. Уут сав, дээс шидмэс, хоол хүнс, зоос мөнгө бүгд хуцанд буй. Ирэхдээ чи заавал зуун зүйлийн бараатай ирэх хэрэгтэй. Олз омогтой яваад ирдэг бол сурлага /сурсан/ чинь тэр. Чадахгүй турж өлбөрдөг бол дөнжиг /хувь/ чинь тэр! гэж хэлээд зуун хуц туулган явуулж гэнэ.

Тэнэг хөвгүүн нь уруу царайлан усан нүдэлж, зуун хуцаа туугаад үг чиггүй замд зөв зүгээр гарч гэнээ. Зуун хоногийн зүг чиггүй замд шүү дээ. Зуур хоногийн айлчны зам биш. Зургаахан алхам дахь хүүхдийн тоглоом ч биш! Явган хоосноор би яаж явж ирдэг билээ? гэж бодон бодон гомдож уяран уйлаад явж гэнэ. Тэгж байтал замд нь нэг наран саран шиг сайхан зүстэй, навч цэцэг шиг өнгө хээмсэг /хээнцэр/ хувцастай тоолбол нас чацуу, төөлбөл нуруу чацуу хөөрхөн бор хүүхэн харгаж гэнэ. Түүний уйлан явахыг үзээд их сонирхож: – Чи юунд уйлав? гэж сурж гэнэ. Аравсар учир явдлаа хэлж өгөхөд хүүхэн их л элэглэн инээж:

– Эр хүн бизээ чи. Эрээн нүдний нулимс чинь ямар хэрэггүй юманд гоождог юм бэ? гэж хэлж гэнэ. Аравсар улам гомдож:

– Явган хүний зовлонг морьтой хүн мэдэхгүй нь зөв. Оготны үхэл муурын наадам болдог нь ч үнэн. Би зуун зүйлийн худалдаа хийгээд буцахыг байтугай зургаахан өдрийн нарыг үзэж чадалгүйгээр зуур замдаа үхэж жилийх гэж байхад чи инээдэг чинь юу буй гээд дахин уйлж гэнэ. Тэгэх тутам хүүхэн улам бүр инээж:

– Чи ямар хэрэггүй юманд уйлдаг хүн буй? Цаашаа угчилаж боддоггүй. Ухаан чинь ууцандаа оров уу? Сүнс чинь сүүжиндээ шингэв үү? Зуун хуц байхад чинь чамд юм бүхэн бүгд байна гэж мэд. Өдөр бүр нэг хуцаа хираалаад /хөнгөлөөд/ бөөрийг /бөөсгийг/ нь идэж явбал зуун хоногийн хүнс чинь биш үү! /аяга сав ч хэрэггүй ямар амархан байна/ Өдөр бүр нэг хуцынхаа хоёр гуаыг хяргаад ноосоор нь даалин нэхээд тохчихвол зуун янзын барааны уут чинь биш үү! Дээс ч хэрэггүй ямар эвгэйхэн байна. Өнөөдөр нэг хуцаа хяргаад ноосыг нь шөнөдөө хөдрөөд өдөртөө мөн хуцан дээрээ ачаад явбал цааш нааш явж ирэх зуун хоногийн хучлага чинь биш үү! Дэлхий их худалдаа арилжаатай газар хүрээд ерэн есөн хуцаа бүгдийг ноосыг нь хяргаж худалдвал зуун зүйлийн барааны зоос биш үү! тэгвэл хуцныхаа хоёр эврийг хөрөөдөж тайраад хэлхэж тохвол эвтэй сайхан янгирцаг биш үү! Тэгчихээд наашаа ачаатай хуцаа тууж ирэхдээ зам зуураа хонох газраа ажиг яв. Хэц /өндөр/ газар хүрээд хэвтүүлж хонох хэрэгтэй. Хэц газар хэвтүүлбэл нэг талын ачаа нь газарт тулчих тул хуцын тэр бие нь амраад амжих биш үү? Нөгөө биеэ хуц өөрөө улирч /эргэж/ хэвтээд амруулчихдаг юм. Үз. Ачих ч хэрэггүй. Буулгах ч хэрэггүй. Яасан амархан байна? Чи гэсэн хүн яасан тэнэг юмдээ гэж зөв сайхан аргаа хэлж өгөөд бас:

– Энэ аргыг намайг хэллээ гэж аавдаа битгий хэл гэж захиад явуулж гэнээ.

Ингээд Аравсар хүү хүүхний хэлсэн ёсоор нь яваад олз омогтой хариад ирж гэнээ. Хойт мэргэн Тэвнэ үзмэгцээ: "Хүүгийн ухаан биш, хүний ухаан байна" гэж бодоод Аравсараас гэнэт асуухад нь наадах нь санамсаргүй хэлээд өгчээ.

– Тэр хүүхний нэр хэн гэнэ? Хаана байна? гэж асуухад тэр:

– Нэрийг нь сурсангүй, байсан газрыг нь мартчихаж гэж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ Аравсарын явсан зүгийг чиглэж хүүхний байх газрыг сураглан явж гэнэ. Явж байтал зам дээр нь нэг хүүхэн чулуун гэр барин наадаж байна гэнэ. Хойт мэргэн:

– Хүүхээ, замаас гэрээн зайлуулж байна уу? гэж хэлэхэд тэр хүүхэн:

– Ах аа! Морь гэрээс зайлдаг уу? Гэр мориос зайлдаг уу? гэж гэдрэг асуучихаад ажиггүй наадаад сууж гэнэ. Хэл аманд орсноосоо хэн хүнд гартагдаж үзээгүй Хойт мэргэн Тэвнэ өнөөдөр санамсаргүйгээр ийм нэг жаахан хүүхэнд аван дороо таглагдаад арга хургаа барсан боловч, дахиж ирэхдээ мохоогоод өгье гэж боджээ.

Дараа жилийнх нь нэг сэр сэр гэсэн намираа бороотой өдөр Хойт мэргэн Тэвнэ сайхь хүүхнийг хайж хүрэхэд хүүхэн малынхаа захад түүсэн аргалаа хормойгоороо хуччихаад өрмөг өмсгөл нэхэн сууж байв гэнэ. Хойт мэргэн Тэвнэ,

– Хүүе хүүхээ! Хормой чинь хурд дэвтэв шүү гэхэд хүүхэн:

– Хормой дэвтэвч аргал хуурай байвал харьж хүрээд галаа түлж цайгаа чанах завсар хормой ч хатчих биш үү гэж хариулж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ:

– Хүүхээ, чи энэ өмсгөлөө эхэлж нэхээд одоо болтол хэдэн архаг /оёдлын шидээс хаваас/ гогцоолов? гэсэнд:

– Ахаа, таны морь гэрээсээ энд иртэл хэд алхав? гэж гэдрэг асууж гэнэ.

Хойт мэргэн Тэвнэ "За, энэ ч нэг зүгээр хүүхэн биш юм байна. Тэнэг хүүд минь ийм нэг бэр таарвал сая гал голомт минь тасрахгүй байх" гэж боджээ. Энэ хүүхэн бол яг Аравсарт арга ухаан хэлж өгсөн тэр хүүхэн мөн байжээ. Уран санаатай, нарийн аргатай Хойт Мэргэн Тэвнэ үргэлжлэн тэнсэх санаатай:

– За, би маргааш дахин ирэхэд чи үнсээр дээс томоод тавьж бай гэж хэлэхэд хүүхэн:

– За, за, томж тавихыг нь би мэдье, эвхэж авахыг нь та мэд гэж хэлж гэнэ. Тэгэхэд Хойт мэргэн Тэвнэ,

– Болно гэж хэлээд явав гэнэ. Хойт мэргэн Тэвнэ явмагц хүүхэн харьж өвсөн дээс томоод маргааш нь нэг үзүүрээс нь галдаад орхиж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ ирэхэд түүнээ зааж:

– Үнсэн дээс тэр байна. Одоо та эвхэж авдаа гэж хэлж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ аргагүй болохдоо:

– Чи үнэхээр тийм сүрхий юм бол би маргааш дахин ирэхэд эр үхрийн сүүгээр тараг бүрээд тавьж бай гэхэд хүүхэн бас л:

– За гэж ажиг үгүй хэлж гэнэ.

Маргааш нь хаяагаа битүүлж, чулуу тээрмээ гадагш зөөгөөд яарч байсан хүүхэн, Хойт мэргэн Тэвнэ холоос ирж байхыг үзээд өмнөөс нь тосон очиж:

– Өнөөдөр манайд хөл цээртэй. Та битгий ир гэж гэнэ.

– Яасан юм бэ? гэж асуухад хүүхэн:

– Аав хөнгөрч байна гэж гэнэ.

Эр хүнээс хүүхэд гарна гэж байдаг уу? гэж асуухад нь:

– Тэгвэл эр үхрээс сүү гарна гэж байдаг уу? гэж гэдрэг нь асууж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ "Энэ хүүхнийг бачим сочим үгээр нэг чадахгүй бол болдог нь биш юм байна" гэж бодоод:

– Үгүй чи яагаад асуултыг асуултаар хариулаад байдаг буй? гэж асуухад:

– Яагаад болдоггүй буй? гэж хариулсан гэнэ.

Хойт мэргэн Тэвнэ энэ хүүхнийг тэнсэж дуусаад ихээр тоож, гэртээ дагуулж хүрээд хүүгээсээ:

– Чамд арга ухаан хэлж өгсөн хүүхэн энэ мөн үү? гэхэд Аравсар таньсангүй гэнэ. Тэгээд хүүхний нутаг ус, нэр насыг нь сурж аваад буцаажээ. Хүүхний аав нь яг тэр нутгийнхаа ноён нь байж гэнэ. Долоон хоногийн дараа Хойт мэргэн Тэвнэ тэр ноёны гэрт хүрч:

Молцог цагаан буйлтай буурын

Монцог хоёр бөхтэй ингэний

Моош /маш/ олон торомны ууган

Хажууд нь хана хүргэж үзээгүй

Хамарт нь буйл хүргэж үзээгүй

Хажиг улаан ингийг сурж явна үзэв үү? гэхэд хааны хиа, учрыг нь олж, ухааныг нь тайлж ядаад долоо хоног гэнэ. Дахиад:

Тэмээ хөтөлдөг нь танайд байна

Тэн өргөдөг нь манайд байна

Цалмын сайнаар морь тогтоодог

Сэлмийн сайнаар төр тогтоодог

Цагаар нийлж гэр тогтоодог

Цаваар нийлж зуу хүрдэг гэхэд бас тайлж чадсангүй долоо хонож гэнэ. Ингэж ядаж байхад хүүхэн нь гарч ирээд:

– "Молцог цагаан буйлтай буур" гэдэг нь аавыг хэлж байна. "Монцог хоёр бөхтэй ингэ" гэдэг нь эхийг хэлж байна. "Моош олон тором" гэдэг нь дүү нарыг хэлж байна. "Хажуудаа хана хүргээгүй, хамартаа буйл хүргээгүй хажиг улаан ингэ" гэдэг нь намайг хэлж байна. Энэ хүн худ ураг больё гэж намайг авахаар ирсэн юм байна гэж тайлав гэнэ. За тэгээд

Далай их баяр болов гэнэ

Далан өдрийн найр болов гэнэ

Дэлхий их хөл болов гэнэ

Дэлгэр их хурим болов гэнэ.

Тэндээсээ Хойт мэргэн Тэвнэ бэрээ аваад гэртээ буцаж ирэв гэнэ. Бэрээ авчраад хадам талын сахил горимыг ямар зэрэг сахиж байхыг нь шалгахын төлөө Хойт мэргэн Тэвнэ туйлын төвөгтэй уран цэцэн аргаар тэнсэж гэнэ.

– Орчлонгийн ус, мод, мал, араатны нэр бүр чинь хадам дээдсийн нэр байлаа. Чи тэр бүхний нэрийг цээрлэх хэрэгтэй гэж тушаажээ. Тушааж бараад нэгэн өдөр нэг муу дардагар эвэртэй хөгшин халзан хуцаа хэргээр хээр орхиж ирээд маргааш өглөө нь бэрээ үзээд ир гээд явуулж гэнэ. Бэр нь яваад хүрэхэд хуцыг нь голын эхний нэгэн саглагар модны ероолд чоно идчихсэн

байж гэнэ. Эргэж ирэхэд нь аав нь:

– Байна уу? гэж асуухад хүүхэд “Гол, мод, чоно, хуц бүгд миний хадмын дээдсийн нэр гэсэн болохоор цээрлэх хэрэгтэй” гэж бодоод:

– Юуны тань байх билээ.

Ургамлын ёроолд

Урсмалын эхэнд

Майлмалын дэрдэн жамц ахыг

Улимал нь ирээд шамшичихжээ. Та

Дэргэр эвэртээ унаад

Сэргэр шийртээ үүрээд явах юм биш үү! гэж хариулж гэнэ. Бас нэг удаа бэр нь нүдүүрийн чулуугаа халаагаад хувцсаа цавдан сууж байхад нь Хойт мэргэн Тэвнэ,

– Нүдүүрийн чулуугаа галаар халаав уу? усаар халаав уу? гэж сорьжээ. Бэр нь:

Могой хэлт

Морин дэлт

Цусан өнгөт

Чавган зүстээр халаав гэж хадамынх нь долоодугаар үед "Галт" гэсэн нэртэй хүн байсныг нь уран цэцнээр цээрлэн хариулсан гэнэ. Монголын бэр хүн хадмынхаа нэрийг цээрлэдэг ёсон үүнээс үүссэн гэнэ.

За тэгээд Хойт мэргэн Тэвнэ

Сайн ч бэртэй

Сайхан ч айл болжээ

Жар ч насалж

Жаргалтай ч амьдарчээ

Уудаг нь болвол

Булгийн судасны ус гэнэ

Иддэг нь болбол

Бугын шандасны мах гэнэ Тэр буга алахдаа бүр аман хүзүүг нь харваж алдаг гэнэ. Хүү нь харвах бүр нэгийг унагадаг боловч аман хүзүүг нь авч яасан ч чаддаг үгүй, ааваасаа асуухад арга эрдэмээ хэлж өгдөг үгүй гэнэ. Иймд бэр нь арга бодож байгаад аавынхаа саадгийг далдуур аваад галд ээж, хатуу болгож гэнэ. Тэгээд Аравсарт:

– Маргааш аав чамаар ан харвуулбал би яаж харвал аман хүзүүг нь харвах буй? гэж асууж аваад харва гэж хэлж гэнэ. Маргааш нь Хойт мэргэн Тэвнэ хүүгээ дагуулаад авлан явж байтал ховор тохиолддог Мэлхийт гэгч буга урьдаас нь давхиад босч гэнэ. Саадгаа авмагц дүүртэл нь эвшээлгэтэл саадаг нь хатсан газраараа "тас" гэтэл хугарчиж гэнэ.

– За болсонгүй. Хүү минь, чи харва гэхэд хүү нь эхнэрийнхээ захисныг бодоод:

– Яаж харвал аман хүзүүг нь авдаг буй? гэж асууж гэнэ. Аав нь арга үгүй:

– Ээ мөн байна. Аргат бэрийн минь ухаан байна. Аманд нь барьж уурыг нь харва гэж хэлж өгч гэнэ.

Аравсар аавынхаа хэлснээр аман уурыг нь харвахад саадгийн сүмбэ /сум/ аман хүзүүг нь авч гэнэ. Үүнээс хойш Аравсар аман хүзүү тас харвах эрдэмтэй болжээ. Гэтэл аав нь энэ буга ганцаар өвчөөд борцолж, хатсан хойно сая гэртээ авчирдаг байжээ. Хүү бэр хоёр нь ямар буга буй? гэхэд яг хэлж өгдөггүй байж гэнэ.

За, тэр үед болвол энэ Монгол газар Тангад газартай зах нийлж байж гэнэ. Тангад газар Соронзонгомбо гэгч нэг хаантай гэнэ. Энэ Соронзонгомбо хааныг Цагаан дарь эх гэдэг. Энэ Цагаан дарь эх илрэхэд заавал ногоон дарь эх ч илрэх ёстой гэнэ. Тэгээд Цагаан дарь эх ба ногоон дарь эх эрхбиш дэр нийлүүлж гэзэг холбох ёстой юмсанжээ. Энэ үед ногоон дарь эх Хятадын хааны гэрт илэрч, нэрийг нь Өнчин гүнж гэдэг байж гэнэ. Түүнийг Хятад орноос Соронзонгомбо хаанд авчрах чадвартай хүнийг бүх Тангад орноос хайгаад олсонгүй тул хамгийн сүүлд хэнээс ч мэргэн, хэлтэй амтай, хэцүү хэрсүү Хойт мэргэн Тэвнэг явуулахаар болсон гэнэ.

Энэ Хятадын орон болбол хамгийн сүрхий хөгжсөн газар. Дэлхийд үгүй хив торготой гэнэ. Хорвоод ховор ховч шар зурхайчтай гэнэ. Энэ ховч шар зурхайч нь болохоор хүн юу хэлж, юу гэж байвч мэдчихдэг гэнэ. Цааш нь хэлбэл адуунд нь аранзал агт заяасан, эмсийн дунд нь ногоон дарь эх заяасан, эрсийн дунд нь гайхалтай долоон эмч заяасан. Энэ долоон эмчийн мэргэжил гэвэл үхсэн хүнийг амилуулж чаддаг гэнэ. Тэгээд Хойт мэргэн Тэвнэ Соронзонгомбо хаанд Өнчин гүнжийг залж авчрахаар Хятадын оронд хүрэхэд энэ Хятадын орноос хатан залж ирэх гэдэг тун бэрх байв гэнэ. Эхэлсээр Хятадын хаан, Тангадын хаанд өгөхгүй гэж маргалдсан гэнэ. Гэвч эцэстээ Хойт мэргэн Тэвнийн хэл амны хурцад дарагджээ. Тэгээд аргаа барахдаа Хойт мэргэн Тэвнэтэй гурван зүйлийн маргаан тавьж гэнэ.

Нэгдүгээр маргаан нь юу буй? гэвэл, дотроо матгар татгар нүхтэй алгын чинээ хаш чулуу авчраад утас сүвлэн гарга гэж гэнэ. Нааш цааш хугас нугас гарсан нэгийг сүвлэх гэдэг ч утсаар үхрийн дотрыг сүвлэж гаргахын адил бэрх хэрэг байв. Гэтэл Хойт Мэргэн Тэвнэ өчүүхэн ч шантарсангүй, хажуугаасаа нэг шоргоолж барьж ууцнаас нь утсаа оосорлоод хашийн нүх рүү тавьж оруулахад удаж удаж цаад талаар нь гараад ирж гэнэ. Одоо

шоргоолжны ууц тасархай байдаг нь үүнээс болсон гэнэ. Хойт мэргэн Тэвнэ ингэж сүвлэсэн хашаа Хятадын хаанд аваачаад өгөхөд хаан хоёрдугаар маргаанаа тавьж гэнэ. Хоёрдугаар маргаан нь юу юм бэ? гэхэд, Хаан:

– Энэ орой их ордонд найр хийнэ. Чи ордонд ороход дагуулах хүн байхаас биш гарахад дагуулах хүн байхгүй. Ордоноос гараад сууж байгаа гэрээ чи өөрөө олж чадвал хүүхнийг аваад яв гэж хэлж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ мянган алд мяндсан утсыг нударгын чинээ болтол бөмбийлгөж ханцуйлаад ирсэн хүнийг нь дагаж гарахдаа утасныхаа нэг үзүүрийг үүднээсээ уяж ханцуйнаасаа цувуулан гаргаад байв гэнэ. Мянган өрх, түмэн тасалгааг дамжиж, гурвалжин дөрвөлжин, уулжин төөлжин хэлбэрт урт саравчийг даган, гулжиг мэлжиг явсаар байтал толгой эргэж хаанаас ирсэн хашаа хандан байгаагаа ч мэдэхгүй байтал хэзээний гол ордонд ороод ирчихсэн байв гэнэ. Шөнө хугаслалат найр болоод, буцаах үед түүнийг ганцааранг нь орхиод явцгаажээ. Гэвч Хойт мэргэн Тэвнэ, айсангүй, сайхь цувуулж ирсэн утсаа дагаад харьж гэнэ. Маргааш өглөө нь хаан:

– Одоо л нэг төөрч хэрмийн ёроолд хэвтэж хоноод маргаанд унасан бий гэж бодон ирж үзэхэд Хойт мэргэн Тэвнэ харин орон дээрээ амирлангуй нойрсон байв гэнэ. Хаан хүүхнээ Тангадад өгөх дур нь эс хүрэхэд хоёрдахь удаа үгээ буцаж гуравдугаар маргаанаа тавьжээ. Гуравдугаар маргаан нь юу буй? гэхэд хаан:

– Гурван өдрийн дараа чиний өмнө гурван зуун ана мана хувцастай, ав адил зүстэй хүүхнийг авчирна. Тэдний дотроос Өнчин гүнжийг таньж чадвал аваад яв гэж хэлжээ. Энэ маргаанаас Хойт мэргэн Тэвнэ ч айж эхэлж гэнэ. Ногоон дарь эх Өнчин гүнжийг таних хүн бараг байхгүй мөртөө таних хүн байхаар бодсон ч ховч шар зурхайчаас айгаад хэлдэггүй юмсанжээ. Хойт мэргэн Тэвнэ арга ядахдаа хааны үүдэн дэх нэгэн зарц эмгэнээс суржээ. Эмгэн ямар ч хариу өгсөнгүй хоёр хонож гуравдугаар өдрөө:

– Өнчин гүнжийг таньж олж авах аргыг миний хүүхнээс асуу гэж хэлмэгц гараад явчиж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ араас нь хөөж гараад:

– Таны хүүхэн хаана буй? гэхэд:

– Энэ өмнө харлан байгаа замгүй эзгүй ууланд золигт гарсан юм /цөлөгдөв/ гэж гэнэ.

– Замгүй ууланд би яаж орж асуух буй гэж асуухад эмгэн:

– Наян үет нарийн цагаан хулсыг найман тэвэр авчраад үе үеэр нь хөрөөдөн тайрч, дахин гуурс гуурсыг нь уулан дээгүүр угсруулан тавиад сурж авах гагц л арга байдаг билээ гэж хэлж гэнэ.

Энэ эмгэний хүүхэн нь яагаад золигт гарсан буй? гэвэл бас л үлгэртэй юм. Хааны ордны зуу, мянган шивэгчин дотор тэр хүүхэн сайхан зүстэй байсныг хаан мэдээд биеэрээ авчран гол ордны шивэгчин болгосон гэнэ. Тэр хүүхнийг гол ордонд авчрах үед хар багаасаа хамт өсч бойжсон лимбэчин хүү:

– Чи явсан хойно би яах буй гэж гэнэ. Хүүхэн:

– Наян үет нарийн цагаан хулсан лимбэндээ миний дууг шингээчихээд сонсон суу тэгвэл намайгаа санахгүй юм гэж хэлээд лимбэнд нь өөрийн дуу, үгээ шингээж өгсөн юм гэнэ. Энэ хүүгийн лимбэ болвол өөрөө дуу гаргах биш, харин шингээж авсан дуугаа гаргадаг юм байж гэнэ.

Ордонд орсон шивэгчдэд өдөртөө дуусашгүй хар ажил хэцүү боловч хамгийн хэцүү нь хаантай хамт унтах ажил гэнэ. Хаан орой болгон нэг шивэгчнийг унтах өрөөндөө аваачаад маргааш өглөө нь алаад хаячихдаг байж гэнэ. Гэтэл хүмүүс юу болсон, хаашаа явсныг нь ч мэддэггүй байжээ. Олон шивэгчин өдрөөс өдөр цөөрсөөр нэгэн өдөр тэр хүүхний ээлж болов гэнэ. Шивэгчид урьдахтайгаа адилаар уйлж унжин түүнтэй үхэж салахын ёсоо хийцгээв гэнэ.

Тэр хүүхэн хааны унтах өрөөнд хүрээд байдаг учрыг нь сая мэдэж гэнэ. Хаан ч гэж шингэн дэлтэй, шил эвэртэй нэгэн зэтгэрийн хүн байж гэнэ. Тэгээд тэр хүүхэн эхэр татан уйлаад байхад хаан их сонирхож:

– Чи юунд уйлж байх буй? гэхэд хүүхэн:

– Та маргааш намайг алах байх гэхэд хаан:

– Би чамайг алахгүй байж болно! хэрвээ чи хүмүүсийн дунд очоод: "Манай хаан гэж нэг шингэн дэлтэй, шил эвэртэй чөтгөр шиг амьтан байна" гэж хэлбэл ард албат бүгдээрээ ирээд намайг цохиод алчихгүй юу! гэж гэнэ. Үүнд хүүхэн хааны өмнө сөгдөөд:

– Хаан аа! Би нэг ч хүнд хэлэхгүй гэж танд андгайлъя. Надаас ондоо ямарч хүн мэдэхгүй бол болсон хэрэг тэр! Би хаандаа андгай тавьсан хойно тантай насаараа хамт унтъя. Тэгвэл надаас ондоо нэг ч хүн мэдэхгүй биш үү! гэжээ.

– Хүүхэн андгай тавиад байхад хаан баахан итгэлтэй болсон гэнэ. Үнэндээ ч тэр ийм сайхан зүстэй хүнийг алах зориггүй байжээ. Ингээд урд урдаасаа аваад одоо болтол шивэгчнүүдтэйгээ анх удаа амьд мэндээр нүүр үзэлцсэн нь энэ хүүхэн болж гэнэ. Гэвч хааны шил эвэртэй, шингэн дэлтэйг хүнд хэлэхгүйгээр нуугаад байх гэгч мөн нэг тэсч чадмаар хэрэг биш байжээ. Хүүхэн үгээ яаж даравч амаар нь гарчих гээд болохгүй тул нэг өдөр голын хөвөөнд хувцас угааж байгаад хажууд нь байсан оготны нүх рүү:

– Хүүе хүүе, таануус мэднэ үү, үгүй юу? Манай хаан гэж нэг шил эвэртэй, шингэн дэлтэй чөтгөр шиг амьтан байна шүү гэж хэлж гэнэ. Ингэж нэг хэлээд орхисон чинь цээж нь нэг онгойх шиг болж гэнэ. Тэгээд ойр холоо ажвал хүн амьтангүй тул баяр баясгалантайгаар ордондоо буцаж гэнэ. Гэтэл манай хаан шил эвэртэй, шингэн дэлтэй гэсэн үг мөн оройгоо ард албат даяарын дунд түгэж гэнэ.

– Учир юу болов? гэвэл тэр оготнын нүх бол сайхь лимбэчин залуугийн орой бүр голын хөвөөнд ирж хүүхнийхээ дууг сонсоод лимбээ нууж тавьдаг нүх нь байжээ. Иймээс хүүхэн тэр нүх рүү хэлэхэд лимбэ дуу үгийг нь шингээгээд авч гэнэ. Тэгээд орой нь залуу ирж лимбээ дуугаргахад хааны нууц ёроолоороо задарсан хэрэг болжээ.

– Хаан нууц задарсныг сонсмогц, хэн задруулав?! гэж ховч шар зурхайчаараа үзүүлбэл, "Хоёр

амтай хулсан чөтгөр задруулав" гэж илэрсэн нь юу болохыг ойлгосонгүй тул тэр хүүхнийг сэжиглэжээ. Сэжиглээд шалтаг олдохгүй тул алах ял тулгаж чадсангүй, аваачаад замгүй эзгүй ууланд золигт гаргасан нь тэр байж гэнэ.

– Хойт мэргэн Тэвнэ тэр замгүй эзгүй ууланд нь хүрээд эхийнх нь захисан ёсоор наян үет нарийн цагаан хулсыг найман тэвэр авчран үе үеэр нь хөрөөдөн тайрч, дахин гуурс гуурсаар нь уулан дээгүүр угсруулан тавьж байгаад Өнчин гүнжийг яаж таньж авах аргыг тэр хүүхнээс сурж гэнэ. Тэгэхэд тэр хүүхэн нарийн гуурсаар:

– Та урьдаар манай гэрийн үүдэн дээр нэг нүх малтаад доор нь эхийг суулга. Тэгээд дээр нь төмөр тогоо нэрж, доор нь тахианы өд, нохойн ноос, элдэв амьтны баасыг хольж түүний дээрээс нь бас хөнгөн цагаан халиваар дар. Хамгийн сүүлд төмөр гуурсаар энэ бүхэн шувтлаад нэг үзүүрийг нь эхийн аманд хүргэж, нөгөө үзүүр дээр нь та чихээ тавиад сонс. Өнчин, гүнж ямар янзтай байдгийг эх тэр гуурсаар танд хэлж өгөх юм. Ганц энэ аргаар ховч шар зурхайч сая мануусыг илрүүлж чадахгүй гэж хэлж өгч гэнэ.

– Хойт мэргэн Тэвнэ тэндээсээ харьж ирээд, хүүхний захиж зангасан ёсоор хийж гүйцэтгэв гэнэ. Тэгээд төмөр гуурсныхаа үзүүр дээр чихээ тавин чагнахад эх нь:

– Ана мана хувцастай, ав адил зүстэй гурван зуун хүүхэн чиний өмнө эгнэхэд чи аргалж байгаад тэднийг инээлгэх хэрэгтэй. Гэтэл тэд амархан инээдэггүй юм. Хэрвээ инээлгэж чадвал тэдний доторх нэг л хүүхний үүдэн цагаан шүдэн дээр "М" гэсэн алтан үсэг буй. Тэр бол даруй Өнчин гүнж авхай мөн. Инээхтэй нь зэрэг бас хамрын хоёр нүхнээс нь хоёр алтан зөгий нисэн гараад эгэм дээр нь хүрэхдээ эрээн цоохор эрвээхэй болох байх. Чи тэднийг заавал инээлгэх хэрэгтэй мөртлөө эрхбиш нэгдүгээр удаа дээрээ инээлгэх хэрэгтэй. Нэг л удаа дээрээ инээлгэж чадахгүй бол бүтсэнгүй нь тэр гэж мэд гэж хэлж өгчээ.

– За тэгээд авхайг таньж авах өдөр нь болов гэнэ. Төвд цагаан толгойн нэгдүгээр эгшиг -га. Хойт мэргэн Тэвнэ хүүхнүүдийн өмнө хүрээд харсан ч үгүй, харин тэднийг инээлгэх аргаа бодож, гаансаа хойно хойноос нь нэрж, архийг байн байн хөнтрөн нааш цааш алхаад байв гэнэ. Чингэсээр байгаад согтож ирэв гэнэ. Өврөөсөө гаансны манхаг /тамхины уут/-аа гаргах гээд харин хүүхдийн эсгий бойтог гаргаж ирээд гаансаа алгуур аажмаар оруулан "тамхиа" малтаж эхлэв гэнэ. Хүүхнүүд үүнийг үзмэгц тэсвэр алдаад унаж бостлоо инээлдэж гэнэ. Инээлдэж байх зуур Хойт мэргэн Тэвнэ нэг л ширэвмэгц үүдэн цагаан шүдэн дээрээ "М" гэсэн алтан үсэгтэй нэг хүүхэн байхыг үзээд амжсан мөртөө хамраас нь хоёр алтан зөгий гарч нисээд эгэм дээр нь хүрмэгц эрээн цоохор эрвээхэй болон хувилж одсоныг ч олоод үзэж гэнэ. Хойт мэргэн тэр хүүхнийг олны дундаас хөтлөөд гарахад хаан, миний хүүхэн ийм ийм тэмдэгтэй гэдгийг лавтай нэг хүн хэлж өгсөн байх гэж бодоод:

– Ховч шар зурхайчийг аваад ир гэж хашгирчээ. Өнөөхөө авчраад үзэхэд: "Тахианы өд хэлэв, нохойн ноос хэлэв, элдэв амьтны баас хэлэв, төмөр хэлтэй уруултай эм чөтгөр хэлэв . . ." гэж зэргээр илрээд байсанд хаан: "Ийм амьтан хаана байх буй цагийн муу ирэхэд энэ бас хэргээ барах юм байна!" гэж уурлаад ховч шар зурхайч номоо галд хаяжээ. Тэр нь шатаж барагдахаасаа өмнө салхинд хийсээд, уулын бэлээр бэлчиж байсан хоньдын далан дээр хүрч наалдаж гэнэ. За ингээд юм бүхнийг тодлон тольддог ховч шарын зурхай хонины далан дээр наалдаж шингэснийг ганц Хойт мэргэн Тэвнэ л үзээд, хожим нь нутагтаа ирж задруулснаас

хойш монгол хүн хонин дал түлж, бэлгэ барин юм үздэг болсон гэнэ.

– За тэгээд Хойт мэргэн Тэвнэ хүүхнийг дагуулан мордох болжээ.

Гэтэл хүүхэн өөрөө ч явах дургүй гэнэ. Үүнд хаан хатан хоёр аман дээрээ хүүхнээ яв яв гэж шаардаж байвч, ардаа хоюул баярлаж зориудаар Хойт мэргэн Тэвнийг хайж ирээд:

– Хүүхэн өөрөө дургүй гэнэ. Одоо яадаг билээ гэж хэлжээ. Хойт мэргэн Тэвнэ:

– Аа гэмгүй. Хүүхэндээ аль дуртай юмыг нь өг. Тэгвэл явах юм гэж хэлээд ажиг ч үгүйгээр ангир хонгор цайгаа алгуур аажим балган сууж гэнэ. Тэд гарч явмагц Хойт мэргэн Тэвнэ авхайн өргөөнд хүрвэл мөн л явахгүй гээд уйлж унжиж байна гэнэ. Хойт мэргэн Тэвнэ ирсэнд:

– Би явах дургүй. Яавал хэлтэрч чадах буй? гэж гуйж гувшив гэнэ. Хойт мэргэн:

– Ээ, ээж аав чинь чамайг аль дуртай юмаа ав гэх байх, тэгэхэд нь чи: "Би явахгүй гэдгийн учир нь огторгуйн наран саран шиг ээж аав хоёроосоо салж чадахгүй байна. Хэрвээ эх аав хоёр минь надад огторгуйн нар сарыг барьж өгвөл би явна" гэж хэл. Чингэхэд эх аав хоёр чинь огторгуйн нар сарыг барьж чадахгүй учраас чи даруй Тангадад явахаас хэлтэрч чадна гэж гэнэ.

Тэгээд хүүхэн гэртээ хүрэхэд хаан хатан хоюул аль дуртай юмаа ав гэхэд нь Хойт мэргэн Тэвнийн хэлсэн ёсоор нар сарыг барьж өг гэж гэнэ. Тэгэхэд аав эх нь сандарч ирээд:

– Одоо яаж нар сарыг нь барьж өгдөг билээ? гэж Хойт мэргэн Тэвнээс асуусан гэнэ. Хойт мэргэн Тэвнэ:

– Ээ түүнд ядах юу байх буй? Бүтэн тээрмийг алтаар шарж, тал тээрмийг мөнгөөр шарж, нар хурцтай өдөр гаргаад үзүүлж өг гэжээ. Чингээд мөн аргаар нь хурц нартай үдийн голд хүүхнээ дуудаж ирээд:

– Нар сарыг бариад ирлээ гэж гаргаж үзүүлэхэд, наранд гялбайгаад сайн үзэгдэхгүй тул үнэхээр нар сар шиг харагдаж гэнэ. Ингээд хааны арга бүхэн эцэслэж, Ногоон дарь эх Өнчин гүнж авхай явахаар болсон гэнэ.

Хаан, хатан хоёр Хойт мэргэн Тэвнээс:

– Одоо энэ нар сар хоёроо юунд боогоод авч явах вэ? гэхэд нь:

– Нойтон нэхийд боогоод ачиж орхи гэж хэлж өгч гэнэ. Тэгээд Хойт мэргэн Тэвнэ мордохдоо Хятадаас Тангадад бас нэг хэсэг модчин, төмөрчин, нэхмэлчин, тариачныг аваад явах гэсэнд, хаан дотроо "Энэ удаа аргалж байгаад үүнийг авч суугаад алж орхихгүй бол хожим хойшид газраас гарч мэдэх гайны үндэс гэж мэд" гэж бодоод:

– Би чиний цэцэн мэргэн ухааныг аргагүй биширч байх тул тэдгээр урчууд, дархадыг явуулаад, оронд нь чамайг үлдээж ордондоо суулгахаар тогтлоо гэж хэлж орхив гэнэ. Тэгээд

Хойт мэргэн Тэвнэ тэдгээр хүмүүстээ хүрээд:

– Эзний үг эргэлтгүй хойно ямар арга байна. Та нар авхайг аваад урьдаар явж байгаарай. Би араас нь гүйцэж хүрье гээд Хятадын хааны ордонд нь сууж хоцорсон гэнэ.

Тэгээд нэг нууц ордонд нь байрлаж, дотор нь нохой, гахай,

тахиа гэх янзын элдэв амьтны сэгийг хурааж дээр нь дэвсгэрээ дэлгэн хэвтээд:

– Надад өвчин тусав гэж ов зохиож /овлов/ гэнэ. Хятадын хаан нэртэй долоон эмчээ залж үзүүлэхэд нь өмхий үнэрт нь ойртохын аргагүй тул цонхоор улаан өнгөтэй ёнхор торгон утас хаяж өгөөд:

– Бугуйнаасаа ороож уяарай гэж гэнэ. Тэгэхэд нь Хойт мэргэн Тэвнэ бугуйнаасаа уясангүй харин гахайн шийрээс уяж өгчээ. Эмч утасныхаа нөгөө үзүүрийг барьж үзээд хаанд:

– Үхсэн туурайтны судас илэрч байна гэжээ. Тэгээд Хойт мэргэн Тэвнэ дахин:

– Гараа сольж уяарай гэхэд нь тахианы шилбэнээс уяж орхиж гэнэ. Эмч барьж үзээд:

– Үхсэн жигүүртний судас илэрч байна гэхэд хаан дэлбэртлээ уурлаж:

– Цагийн муу ирэхэд таануус ч юм мэдэхээ байхнээ гээд байдаг нэртэй эмч нараа бүгдийг нь цавчаад алчихаж гэнэ. Тэгээд Хойт мэргэн Тэвнэгээс:

– Одоо яавал таны өвчин аялдаг /эдгэдэг/ билээ? гэхэд:

– Хив торгоны үнс идвэл магадгүй гэж гэнэ. Хаан бүх улсынхаа торго хивийг түлэн барьж байж сая нэг атга үнс олж өгчээ. Хойт мэргэн Тэвнэ үнсийг нь идчихээд:

– Бас л аядсангүй. Одоо манай бурхан шашин намайг нутагтаа буцсангүй мөртөө шашин бурханаа шүтсэнгүй гэж уурлаж байна. Би нэг овоо тахиад ирье гэсэнд хаан зөвшөөрч, долоон түшмэлээ өгөөд:

– Овоо тахиад юу хэрэгтэй билээ? гэхэд нь:

– За, долоон мантуу, долоон лонх архи өгвөл болно гэж гэнэ. Хаан өгчээ.

Хойт мэргэн Тэвнэ адуун дундахь ганц аранзалыг нь унаад, долоон түшмэлийг нь дагуулан мордож гэнэ. Тэгээд нэг уулын толгой дээр гараад их л ном гүрэм хийж байх мэт маяглан суусаар байгаад нэлээд орой болгожээ. Долоон түшмэл хажуугаас нь харж суусаар байгаад харангадаж ундаасан харанхуйлж унахад хүрэхэд нь сайхь долоон мантуундаа долоон шил архиа шингээгээд:

– Бурханы сан хүртэм үү! гэж долоон түшмэлд нэг нэгийг өгч гэнэ. Түүнийг нь идээд долоон түшмэл дороо согтож унажээ. Тэгэхэд Хойт мэргэн Тэвнэ долоон мориных нь сагагийг цавчиж хаяад, ганц аранзалыг нь унаад дутаачихжээ.

Долоон түшмэл маргааш нь сая сэргэж, Хойт мэргэн Тэвнэ оргосныг мэдэж хөөх гэхэд нь морьд нь сагаг үгүй тул явганаар ордондоо буцаж ирсэн гэнэ. Хаан уурлахдаа бүгдийг нь яллан цавчиж гэнэ.

Хойт мэргэн Тэвнэ наадуулаа хөөн хөөсөөр дундаа нарийн урсгалтай, дээрээ нягт ургамалтай нэгэн уулан дээр хүрээд гүйцжээ. Өнчин Гүнж унаанаасаа буучихаад:

– Би гэр нутаг, ээж ааваа санаж байна. Одоо би явахгүй гээд уйлан сууж байж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ:

– Тэгвэл чи сайхь аав ээж чинь барьж өгсөн нар сар хоёроо гаргаж үз л дээ. Түүний дотор гэр нутаг, аав ээж чинь илрэн тодорно гэж хэлжээ. Өнчин Гүнж үнэхээр ч тийм буй гэж бодоод, ачаа хөсгөө буулгаж сайхь "нар, сараа" гаргахад алт мөнгө нь нялцгай нэхийд наалдаж хуураад, нутаг ус, аав ээж нь илэрсэнгүй харин бүтэн тал хоёр хөх чулуун тээрэм нь илэрч гэнэ. Тэгэхэд Хойт мэргэн Тэвнэ:

– Иш, хүүхээ! Аав ээж чинь ч чамайг далдруулж ядаж байж шүү. Үзээч! Чамайг хоёр хөх чулуугаар мэхлээд явуулсан байхыг. Ийм чулуу шиг зүрхтэй аав ээжийг санаад ямар хэрэг байх вэ? гэхэд, Өнчин гүнж авхай ч:

– "Үнэхээр ч тийм л байна" гэж бодоод сайхь нар сар гэж өгсөн хоёр чулуугаа тэр хөтөл дээрээ хаяж орхиод зориг шуудран цаашаа явж гэнэ. Ингээд тэр хөтөл нь "нар сарны хөтөл" нэртэй болж, одоо болтол мөн нэрээр дуудагдсаар иржээ.

Тангадад хүрсэн шөнө Хятадаас Соронзонгомбо хаан ба Өнчин гүнж хатанд хорт могой тавьж гэнэ. Хааны унтах өргөөнд харуул хийж байсан Хойт мэргэн Тэвнэ могойг нь цавчиж алахад нэг дусал цус нь үсрээд унтаж байсан хатны хацар дээр тусчиж гэнэ. Тэгээд тэр цусыг нь сэлмээрээ хусаад авья гэхэд шинэ хатны хацар дээр шарх сорви үлдээхээс айгаад хэлээрээ долоон авсан гэнэ.

Маргааш нь хатан босоод хаандаа:

– Тэр чинь шөнө ирж намайг нэг үнсэх шиг болов гэхэд хаан Хойт мэргэн Тэвнэд хилэгнэж, хоер нүдийг нь малтаж аваад ухархайд нь хар тос буцалган хийж, гар хөлд нь гав гинж зүүлгээд хар гэрт хаячихаж гэнэ.

Хойт мэргэн Тэвнэ Тангадад хүрч ирсэн тухай бэр нь доор нь олоод сонсож гэнэ. Гэвч хүлээгээд, халиагаад /хараад/ гурван жил болтол сураг чимээ үгүйд нэг хэрэг гарсныг нь мэдэж, яаж аварч авах аргаа бодон сууж байтал, нэгэн удаа Тангадын орноос хэдэн хүн ирж, хааны ордны ачаа аянд хамаг сайн шар авна гээд явж байсанд нь сайхь хурдан шар "Хар хилэн согсур"-аа худалдаад явуулж гэнэ. Тэгээд: "Аав минь" хар хилэн согсураа" таньж аваад унаж зугтаавал лав гарч чадах байх* гэж боджээ. Энэ бүхнийг нь Аравсар мэдсэн ч үгүй гэнэ. Бүсгүй нь харин: "аль нэг өдөр аав минь "хар хилэн согсураа" унаад гэнэт хүрээд ирэх байх" гэж баярлан харж, хуруу даран хоног тоолсоор байв гэнэ. Гэтэл аав нь ирсэнгүй харин Тангадын хааны ордоноос гурван ху ху /худун/ элч хүрээд ирж гэнэ. Тэд Хойт мэргэн Тэвнэгээс гэртээ хэлүүлсэн үгийг авч хааны зөвшөөрлөөр ирсэн байжээ. Хойт мэргэн Тэвнэ

энэ гурван элчээр ямар үг явуулсан буй? гэвэл:

“Та нар очоод намайг ёстой сайн сайхан амьдарч байна гэж хэл. Оосор бүчгүй өндөр цагаан өргөөнд сууж, цэнхэр торгоор хучиж, хөх хивсэн дээр хөлбөрч байна гэж хэл. Ясгүй мах идэж, шааргүй цай ууж байна. Өдрөөр хоёр зул барьж, өвөр дотроо зүү сүвлэж байна гээ. Манайд бас гурван мухар халтар ирэг буй. Нэгийг нь гийчин очиход шүүс гарга гээ. Нэгийг нь зам дунд шүүс барь гээ. Нэгийг нь үүд таниулж аваад шүүс барь гээ. Ирэхдээ надад бэлэг сэлт хэрэггүй, зөвхөн зуун хэрээний уран хоншоор тааруулж ир гэж хэл. Баруун биеийн багир хар тонгоргийг зүүн биеийн зүнэр улаан билүүнд сайн билүүд. Хатгуураа бат хавчуул. Хайсын /тогооны/ халиваа бат дар гээ” гэж хэлүүлсэн байж гэнэ.

Аравсар, аав нь сайн байна гэхийг сонсоод аргагүй баярлахад, бэр нь сонсоод бэрх зовж гэнэ. Тэгээд Аравсараа гадна дагуулж гараад:

– Аав минь юуны сайн сайхан жаргаж байх билээ. Харин хоёр нүд нь сохроод өндөр хүрээ дотор үхэр мал шиг хоригдож байгаа юм байна шүү. "Оосор бүчгүй өндөр цагаан өргөө" гэдэг нь хэрмээ хэлжээ. "Цэнхэр торгоор хучиж, хөх хивсэн дээр хөлбөрч байна" гэдэг нь тэнгэрээр хучлага болгоод, үнсэн дээр хэвтэж байна гэсэн үг. "Ясгүй мах идэж, шааргүй цай ууж байна" гэсэн нь баас шиг хоол идэж, шээс шиг ундаа ууж байна гэсэн үг. Харин "Өдрөөр хоёр зул барьж, өвөр дотроо зүү сүвлэж байна" гэсэн нь хоёр нүд сохорсон боловч ухаан санаа саруул эрүүл байсаар, цээжин дотроо нарийн ухаан бясалгаж байна гэдгээ хэлжээ. Тэгвэл тэр "Гурван мухар халтар ирэг" гэдэг нь мөн энэ гурван элчийг хэлжээ. Нэгийг нь гэртээ ал, нэгийг нь замдаа ал, нэгийг нь аавын хоригдож байгаа хүрээний үүдийг хэлүүлж аваад ал гэсэн юм байна шүү. "Зуун хэрээний уран хоншоор тааруулж ир" гэсэн нь зуун янзын цоожинд таарах түлхүүр олж ир гэсэн байна. Тэгвэл "баруун биеийн багир хар тонгорог" гэдэг нь чамайг хэлж, "Зүүн биеийн зүнэр улаан билүү" гэдэг нь намайг хэлж. "Сайн билүүд" гэдэг нь намайг чамд ухаан сайн хэлж өг гэсэн байна. "Хатгуураа бат хавчуул, хайсны /тогооны/ халиваа бат дар" гэдэг нь чамайг гурванд эндээс гарч, арван таванд тэнд хүрч ир гэсэн юм гэж аавынхаа ёгт далд үгийг бүгдийг зөв тайлсан байж гэнэ.

Тэгээд шинийн гуравны хатгуур сартай шөнө Аравсар нэг элчийг нь алж, хоёр элчийг нь баглаж ганзагалаад мордов гэнэ. Мордохын өмнө бүсгүй нь захих зүйлсээ долоо дахин сайн захин мордуулсан боловч ямар ч ухаант бэр гээд заавал нэг мартдаг юм байж гэнэ. Юу мартав? гэвэл "хар хилэн согсур" нь одоо Тангадын хааны ордны сүрэгт байгааг Аравсарт хэлэхээ мартаж гэнэ.

Аравсар нэг элчийг нь замдаа алж хамгийн сүүлд нэг элчийг бүсгүйнхээ захисан ёсоор:

– Чи аавын хоригдож байгаа хүрээний үүдийг хэлж өгвөл амийг чинь хэлтрүүлнэ. Үгүй бол ална гэж сүрдүүлэн байж хэлүүлэн аваад сая алсан гэнэ. Тэгээд аавыгаа аваад дутаан гарахын эхэн дээр харуулд нь мэдэгдчихэж гэнэ. Үүнд Хойт мэргэн Тэвнэ:

– Халаг яалай! Хар хэлэн согсур минь байсан бол хаанаас ийм лайд харгах буй? Харьж буцъя хүү минь! гээд харуулыг нь дагаж хар ордонд нь дахин орж гэнэ.

Түүнээс хойш хүүтэйгээ хоюул аргал хатаах зарц нь болсон байжээ. Нэгэн өдөр хоюул

байхдаа аав нь нэг сарлагийн баасан дээрх туурайн мөрийг тэмтэрч тэмтэрээд, Аравсараа дуудаж:

– Хүү минь, энэ баасан дээрх мөрийг сайн үзэж ав. Тэгээд аль шар нь ийм мөртэй байхыг сайтар ажиглаж бай. Үзэгдвэл л аавдаа хурдан хэл гэж захиж гэнэ. Нэгэн удаа хүү Аравсар нь: сарлагийн баасыг хавтгайлан хатааж:

– Би тэр шарыг олоод авлаа гэчихсэн баяртай хүрээд ирэв гэнэ.

– За хүү минь! Тэр шарыг хаана уясныг нь үзээд ав. Хоюулаа энэ шөнө тэр шараар зугатъя. Тэр чинь манай "хар хэлэн согсур" байна шүү! гэж хүүхэд шиг баярлав гэнэ.

Чингээд хоюулаа мөн шөнөө "хар хэлэн согсураараа" зугатаан гарч гэнэ. Харуул мэдсэн боловч хойноос нь хөөгөөд тоосыг нь ч эс үзэж гэнэ.

Аравсар "хар хэлэн согсуртаа" ааваа сундлан зугатаагаад л байжээ. Хичнээн давхисныг өөрөө ч эс мэджээ. Гэнэт аав нь:

– Хар хэлэн согсур газар үнэрлэж байна уу? гэж гэнэ.

– Үгүй байна гэж гэнэ.

– Одоо? гэж гэнэ.

– Бас л үгүй байна гэжээ.

Энэ мэтээр явсхийгээд явсхийгээд л сураад байж гэнэ. Тэгж байтал "хар хэлэн согсур" нь гэнэт яваагаараа газар үнэрлэн эхлэв гэнэ.

– Аав, аав! "Хар хэлэн согсур" одоо л газар үнэрлэж байна гэхэд аав нь:

"Буу, уу! Үнэрлэсэн газар нь малтаад үз, юу үзэгдэхнэв? гэж хүүгээ буулгаж гэнэ.

– Тээрэм шиг том хөх чулуу үзэгдэж байна.

– Ээ мөн байна! Тойруулан малтаж байж аваад хаяж орхи. Тэгвэл юу үзэгддэг юм байна!

– Тэгвэл, За одоо аваад хаялаа! Доороос нь хөх цагаан хоёр үндэс гараад ирэв.

– Ээ таарав. Тэр чинь газрын үндэс биш, усны судас байна. Тэр хөхийг нь тэвнээр хатгачихаад хар тогоогоо тосоод орхи. Хоюулаа нэг цай чанаж ууя. Тэгээд хоюул цайгаа чанаж ууж үдлээд морджээ. Явж байгаад аав нь гэнэт ардаа эргэж үнэрлээд:

– Хөвгүүн, хөвгүүн, ардаа хар! Усны үнэр гарч байдаг юу билээ? гэхэд Аравсар эргэж хараад:

– Ээ, Тэнгэр газар нийлсэн хөх ус гүйцээд ирж байна! гэжээ.

– Хүүе чи тэр дүгрэг хөх чулууг ормонд нь тавихаа мартсан биш биз?!

– Ээ тавьсангүй.

– За аав нь баахан тэнэгдлээ. Хурдан давхи! Ингээд "хар хэлэн согсурынхаа" хар хурдаар давхиж эхлэв гэнэ.

– Хөвгүүн, хөвгүүн! Ус одоо хаана ирж байна?

– Мануусыг хэдүйнээ гүйцээд хар хэлэн согсурын туурай далдарч байна.

– Түргэн гүйлгэ! Одоо хаана ирж байна?

– Хар хэлэн согсурын борви цохиж байна.

– Гүйлгэ, гүйлгэ! Одоо хаана байна?

– Одоо бүр болохоо байлаа, гэдсэнд нь хүрч ирлээ!

– Хар хурдаар нь, хамаг хурдаар нь гүйлгэ!

– Одоо?

– Оо! Одоо намдаад ирлээ. Дахин борвинд нь хүрэв. За, улам намдлаа, одоо туурай нь үзэгдэв.

– Ээ, тэгвэл зүй болжээ! Одоо юу үзэгдэж байна?

– Тэнгэрийн захад хоёр хар шувуу нисч байна. Энэ үед орчлонгийн өрцөнд усан гамшиг болж байхыг тэнгэрийн хаан үзээд: "Түүнийг дараад ир" гэж хоёр хан гарьдаа явуулсан нь тэр хоёр шувуу байжээ. Хоёр хан гарьд ирж Данчин уулын толгойг таслан /Данчин уул Хөх нуурын баруун өмнө буй. Оройг нь хөрөөдсөн шиг эгц тасархай байдаг/ чулуудаад сайхь усан судсыг бөглөжээ. Энэ нь одоогийн Хөх нуурын хүйс болж, гарсан ус нь Хөх нуур болсон нь тэр гэж хэлдэг. Данчин уул ч одоо болтол оройгоороо эгц тасархай байсаар. Тэр үед Сөмнө Сөнөгэм гэгч шулмас:

– Орчлонгийн орныг усаар авах гэсэн юм. Миний заяа болдог байна. Түүнийг бөглөсөн бөглөөс нь аваад хаяхад яана гээд хадны хэлтэрхийгээр дэвүүрдэхэд чулуу нь хүрсэнгүй наана унасан нь одоогийн Хөх нуурын хүйснээс хойхно цувран үзэгдэж байгаа цагаан хаднууд тэр гэдэг юм.

– За тэгээд аав хүү хоюул гэртээ харьж хүрээд хамтаараа амьдрах болов гэнэ. Хүү нь өдөртөө ан гөрөө хийдэг гэнэ. Нэгэн өдөр нэг буга алаад өвчиж үзвэл өөх нь бүр мэлхий байж гэнэ. Аравсар түүнээс нь цээрлэж жигшихдээ бугынхаа махыг хээр хаяад, ирж бүсгүйдээ хэлэхэд бүсгүй нь очиж өөхнөөс нь жаахан авчран төмөр шанаганд тавьж, галд унгатгаад утаагий нь аавынхаа өмнөөс эвтэйхэн үлээв гэнэ. Аав нь утааг үнэртмэгц өндийж ирээд,

– Хүүе, хүүе "мэлхийт буга"! гэж ам алдаад хэн алав? гэж асуужээ. Хүү бэр хоёр нь "мэлхийт буга" гэж чухам ямар учиртай, яасан буга болохыг ааваасаа хичнээн сураад бас л эс хэлж өгч гэнэ.

– Энэ үе бол яг Алтан зуу – /Лхас/-ыг байгуулж байсан үе гэнэ. Боталын ордныг байгуулах дээр Тангадын байдаг урчууд бүгд цугласан боловч бүтээж чадахгүй үйлээ үзэж, үсээ тоолж байж гэнэ. Боталын ордныг өдөр нь бариад тавихад шөнө нь нурж, шавар нь шавартаа, чулуу нь чулуундаа ялгараад явчдаг байжээ. Яг арга ядахдаа Далай лам, Банчин эрдэнэ хоюул хоёр бадарчин ламын янзаар хувцаслаад Хойт мэргэн Тэвнэгээс арга мэргэжлийг нь хулгайлахаар хавчиг үүргээ чирсээр хүрч ирэв гэнэ. Хойт мэргэн Тэвнэ:

– За таануус хаанаас ирэв? гэж асуухад хоёр лам:

– Мануус Алтан зуугаас ирлээ гэж худал хэлж гэнэ. Алтан зууг бариад барж уу? гэж лавлаж асуухад тэд:

– Боталын ордныг нь бариад аль хэдийнэ баржээ гэж хариулж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ жаахан итгэж ядан:

– Ямар ч түргэн юм бэ дээ . . . тийм амархан, ийм түргэн барьчихлаа гэж үү? гэж бас асууж гэнэ.

Алтан зуу, Боталын ордонтойгоо аль хэдийнээ байгуулагдчихлаа гэхийг Хойт мэргэн Тэвнэ баахан итгэхгүй байжээ. Тэгээд Банчин эрдэнэд хурц тонгорог өгч үс хусуулаад, Далай ламын хоёр гарынх нь дөрвөн хурууг атгаж аваад:

– Таануус тэгээд барс жилийн барс сарын барс өдрийн барс цагт гарсан долоон настай хүүг Боталын ордны гол тулгуур дор амьдаар булав уу, үгүй юу? гэхэд нь Далай лам: – Өө тэглээ тэглээ! гэх зуур хөлийн хуруундаа бийр хавчуулж байгаад эдгээр үгсийг нь тэмдэглээд авч гэнэ. Энэ мэтээр Хойт мэргэн Тэвнэ ингэж хийв үү үгүй юу? Чингэж хийв үү үгүй юу? гэж асуугаад байхад нь Далай лам:

– Ээ тийм тийм, ингэсэн, тэгсэн гэж хариулахын хамт хэлснийг нь хөлөөрөө тэмдэглээд байж гэнэ. Тэгээд удахгүй барагдах гэж байхад Далай лам баярлаад тэсэлгүй санамсаргүйгээр хөлөө чанга хөдөлгөөд цаасаа дуугаргачихаж гэнэ. Хөлөөрөө тэмдэглэж байхыг нь Хойт мэргэн Тэвнэ мэдмэгц, Далай лам хуруугаа татаж, цаасаа шүүрэн Банчин эрдэнээ чирээд зугатан гарч гэнэ. Хэрэг нэгмөсөн хазайсныг мэдмэгц Хойт мэргэн Тэвнэ хөвгүүнээ дуудаад:

– Хөвгүүн, хөвгүүн! Хоер гийчин аавын чинь хэлийг сугалаад авчлаа, булаагаад ир! гэжээ. Аравсар тэр хоёрыг гүйцэж хүрээд:

– Аавын хэлийг гаргаж өг! гэхэд тэд нэгэн горхины хэл өгөөд буцаачиж гэнэ. Аав нь үзээд:

– Ишш! хүү минь. Тэд аавын чинь хэлсэн үгийг бичээд авчлаа шүү. Ийм хэл гэсэн биш. Ээ! Одоо яахав. Тэднүүс холдож, мануус хожигдлоо. Хүү минь дахин гараад үз. Энэ хоёр амьтан

гадна юм орхиж уу? үгүй юу? гэхэд Аравсар гарч очоод гэр түшүүлж орхисон хүв хүнд хоёр хулсан таягийг нь авч орж ирээд аавдаа бариулжээ. Аав нь барьж үзээд:

– Надад үлдсэн шан нь энэ байх. Дотор нь таг дүүрэн үйрмэг алт байна гэж гэнэ.

Далай лам, Банчин эрдэнэ хоёр харьж хүрээд удсангүй Боталын ордныг байгуулав гэнэ. Гэтэл хамгийн сүүлийн баруун хойт өнцгийн барилгыг яаж барьдгийг Хойт мэргэн Тэвнэгээс тэмдэглэж амжсангүй тул тэр хэсэг нь баахан эв хавгүй баригдсан бөгөөд тэр нь одоо болтол уг хэвээр байсаар гэнэ.

Тэгээд Тангадын оронд Зуу тогтсоныхоо их баяр хийхээр болж, Соронзонгомбо хаан биеэрээ хүн томилон Хойт мэргэн Тэвнийг их баяртаа залж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ хүрээд Соронзонгомбо хааны өмнө очиж хэргээ цагаатган хэлсэн нь:

– Танд хатан залахын төлөө би, тамтай хол газар явж, тархи толгойгоо шавхсан биш үү. Тамир хүчээ гаргасан биш үү? Тэр шөнө Хятадаас хорт могой тавьсанд би унтах нойргүйгээр таны үүдэн дээр сахиж байгаад ирэх могойг цавчсанд, цус нь цацраад Ногоондарь эхийн хацар дээр дусчлаа. Би таны хатантай ханилсангүй, харин сэлмээрээ цусыг хусаж авахаас айгаад хэлээрээ долоож авсан юм. Гэтэл та намайг хатантай халдлаа, ханиллаа гэж хэлээд хоёр нүдийг минь сохлож хаясан биш үү . . . Тэр үнэнийг одоо танд гэрчилнэ гээд хүний сүү, сарлагийн сүү, хонины сүү, ямааны сүү хольж аяга дүүргэн өмнөө тавьчихав гэнэ. Тэгээд саадгаа аван тэнгэр өөд нэг харваад:

– За хаан минь үзэж бай хэрвээ би тэр үед хатантай чинь ханилсан үнэн бол энэ саадгийн сум нь эргэж ирээд миний орой руу тусч би үхэх юм. Хэрвээ ханилсангүй байвал энэ сум аягатай сүүнд тусч сүү нь миний нүдэн өөд сацраад би дахин хараатай болох юм гэж гэнэ. Ингэж байтал саадгийн сум нь үнэхээр аягатай сүү рүү унаад, сүү нь нүд өөд нь сацарч, Хойт мэргэн Тэвнэ дахин угийнхаа адил хараатай болж гэнэ. Тэгээд хаан яах аргагүй итгэж, гэм хоргүй ачтай хүнээ хилсдүүлж, хэдэн жил зовоосондоо гомдон Мэргэн Тэвнийн хилсийг цагаатгаж ордондоо залан хүндэлж, их бэлэг сэлт, шан хүртээмж өгөөд харихад нь тусгай хүмүүсийг томилон гэрт нь хүргүүлж гэнэ. Хүү бэр хоёр нь аавынхаа "хараа нүдээ олж, хар гөрөөс салаад, баян бараатай, ноён биетэй харьж ирэхийг үзээд ухаангүй баярлаж гэнэ. За үүнээс хойно Хойт мэргэн Тэвнэ хүү бэр хоёртойгоо бас ан ав хийж амьдрах болж гэнэ. Нэгэн өдөр хүү нь анд гараад нэг "мэлхийт буга" алаад ирж гэнэ. Аав нь үзээд хурдхан очиж махыг нь жаахан ч үлдээлгүй борцолж хатааж гэнэ. Чухам ямар учиртайг асуугаад ч аав нь хэлж өгдөггүйг хүү бэр нь мэдэх болохоор зүгээр л ухааныг нь олохгүй харж хоцорчээ.

Нэгэн өдөр бэр нь:

– Аав аа "мэлхийт бугын" махыг заавал борцлон хатааж иддэг ямар ухаантай юм бэ? гэж аваасаа асууж гэнэ. Хойт мэргэн Тэвнэ хэсэг бодож сууснаа:

– "Мэлхийт бугын" мах хүний тархинд их сайн байдаг билээ. Иймээс борцлон хатааж идэхгүй бол хүн бүр сүрхий хурц ухаантай болдог юм гэж хэлж өгч гэнэ. Тэгэхэд бэр нь:

– Хүүе тийм болвол борцлоогүйгээс нь үүнд /нөхрөө зааж/ жаахан идүүлбэл ухаан санаа

жаахан орох болов уу? гэж асуухад Хойт мэргэн Тэвнэ:

– Ухаан санаа орох нь ч лав орно. Гэвч тэгж идүүлж болохгүй гэж толгойгоо сэжиж гэнэ. Бэр нь гайхаж:

– Яагаад тэр вэ? гэж асуухад

– Би өөрийн үрдээ хар санаж байгаа биш харин цагаан санаж байгаа юм. Хэрвээ Аравсар бас бид хоёртой адил хүнээс хэт ухаантай болчвол энэ гэр задарч сарних нь тэр. Нэг гэрт гурван ухаантай хүн хамт амьдарч чаддаг ёсон үгүй юм гэж аав нь хэлж гэнэ.

Түүнээс хойш бэр нь бодон бодоход эр нөхөр нь арай тэнэг, байх шиг бодогдож “Үгүй ер тийм сүрхий их ухаан орох ч хэрэггүй, жаахан л ухаантай болчвол болно” гэж бодоод ааваасаа нууж байж борцлоогүй "мэлхийт бугын" махнаас нэг жаахан авч чанаад Аравсарт идүүлж гэнэ. Үүнээс л эхэлж Аравсарын ухаан санаа үнэхээр өдрөөс өдөр саруулжиж, юмны ухааныг бодож сэтгэж чадах бөгөөд өөртөө арга ухаан гаргаж ч чаддаг болж ирэв гэнэ. Нэгэн өдөр Аравсар бас л түрүүний адил гадагш гараад зээр харван давхиж байтал саадгийн суманд нь нэг хээлтэй зээр оногдоод хэвлий нь задарч, дотроос нь нэг, өдөр сар нь гүйцсэн янзага гараад унав гэнэ. Аравсарын зүрх "хөв*" гэж долгион, харж чадмааргүй болохдоо нүдээ аньж гэнэ. Аньж байгаад дахин нэг харахад сайхь янзага мориных нь омруу доор унаж босон эхийнхээ хойноос зугатаж байна гэнэ. Аравсарын өр зүрх нь голоосоо уярч "эвий хөөрхий, ийм хөөрхөн амьтныг би юунд харвалаа даа*" гэж бодон бодон гомдсоор тэр мөртөө гэртээ харьж гэнэ. Түүнээс хойш тэр анд явж амьтан алах зориггүй болжээ.

“Халуун хошуутай амьтныг алах минь юу билээ. Үгүй би ер ийм нүгэл хилэнц хийж амьдрахын оронд хол газар очиж эрдэм сураад лам болж амьдарвал долоон дээр биш үү” гэж бодох тутам тэсгэл үгүй явмаар санагдаж гэнэ. Тэгээд нэгэн өдөр аавынхаа өмнө очиж:

– Одоо би амьтан алж нүгэл хийхгүй, хол явж ном хар цээжлээд лам брлно гэж хэлээд Зууг зүглэн мордоод явж гэнэ. Тэгэхэд нь аав нь: Тэр тэнэг амьтан явж явж эс болохдоо буцаад ирэх байлгүй гэж юу ч мэдэхгүй санаа тайван сууж байв гэнэ. Гэвч учиртай бэр нь л санаа амаргүй байж, байн байн дурсан, өдөр хоног тоолоод байдаг гэнэ. Явсан хүн сураг ажиг байдаггүй гэнэ. Хүлээгээд сар жил болов гэнэ. Аравсар эргэж ирсэнгүй. Тэгэхэд бэр нь: Би араас нь явалгүй горьгүй. Би олж аваад дагуулан ирье, аав хүлээж бай гэж хэлээд хүүхдээ үүрэн эрийнхээ явсан зүгт мөрдөн мордож гэнэ. Аав нь ганцаар сууж хоцрон хүлээж гэнэ. Жилийн жилд чимээ сураг таг яг гэнэ. Хэдэн жилийн дараа үрийнхээ хойноос хараагаа шавхан, хүлээхийн цөхөл амсаж суусан Хойт мэргэн Тэвнэ бас нэхээд явсан гэнэ. Чухам хаашаа нэхсэнийг хэн ч мэддэггүй учраас үлгэр ингэж харамсалтай тасардаг билээ.

Төгсөв